

MNG55 Чулуунхайс байгуулж чацаргана хүнсний ногоо тариалах

Мянгад сум нь Ховд аймгийн Баруун хойт захад өмнө баруун талаараа Буянт, Ховд, Эрдэнэбүрэн хойт талаараа Увс аймгийн Өмнө-говь, Өлгий сумтай зүүн талаараа Дөргөн сумтай хиллэн Ховд аймгийн төвөөс 37 км Улаанбаатараас 1470 км-т оршино.

Мянгад сумын нутагт тус технологийг хэрэгжүүлсэн бөгөөд сумын төвийн орчны ашиглалт багатай доройтсон газрыг сэргээн сайжруулахад чиглэсэн агрономын болон ургамалжуулалт хосолсон технологи бөгөөд усалгаатай нөхцөлд малын тэжээл тариалах, чацаргана, ойжуулалт хийж байгаль орчныг нөхөн сэргээх замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой юм.

Технологи хэрэгжүүлсэн газар нь мянгад сумын төвөөс зүүн тийш 3км зайд орших Ховд голын адаг орчмын цөлжүү хээрийн ландшафт бүхий баглуур-хялгана-шарилж-харганат хайрга чулуут тэгш тал бүхий Зулай толгой хэмээх газар бөгөөд тус газарт чулуун хашаан хамгаалалт хийж чацаргана болон хүнсний ногоо тариалсан байна. Одоогоор малын бэлчээрт ашиглагддаг үржил шим муутай цөлөрхөг хээрийн бор хөрстэй бөгөөд тариалалтад усалгаа, бордоо, чулуун хамгаалалтын хашаа зэрэг нь технологи хэрэгжих гол нөхцөл болж байна.

Чацаргана тарихаар бэлтгэсэн талбайгаа сонгосны дараагаар хэд хэд удаа услах ба суулгацаа нүхэнд суулгахын өмнө сайжруулж бэлтгэсэн хөрсөө нүхний гүнийн гуравны нэг хувь хүртэл дүүргээд 40-60 л ус хийж услана.

Бутны эгнээ хооронд 4 м, бут хооронд 2-2,5 м зайтай, өөрөөр хэлбэл нэг бутанд 6 м. кв-аас багагүй хэмжээтэй тэжээлийн талбай оногдохоор тарих бүдүүвчээ сонгож авна, Чацарганы суулгацыг хавар, намрын аль ч улиралд тарьж болох бөгөөд хавар тарих бол бутны нахиа хөөхийн өмнө буюу 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр, намар тарих бол газар хөлдөхөөс 20-40 хоногийн өмнө буюу 9-р сарын сүүлч, 10-р сарын эхээр тус тус тариална. Нүхэндээ суулгацаа суулган үндэсний үзүүрээс дээш 10-15'см зузаан.нойтон шороогоор булаад суулгацаа тойруулан зөөлөн гишгэж шороогоо нягтруулан чигжинэ. Суулгацыг тарьсан өдөртөө ус гүйх шан ба нүхээ усаар дүүргэн сайтар услана. Ус газрын хөрс рүү шингэж дууссны дараа суулгацын хазайлт, үндэс нь ил гарсан эсэхийг шалгаж, хэрэв зөрчил илэрвэл, гадас шааж уяж тэгшлэх, бага зэрэг шороо нэмж өгөх зэргээр хамгаалалтыг сайжруулна.

Усалгааг аль болохоор суваг, шуудуу ашиглаж хийх хэрэгтэй бөгөөд 9-р сарын сүүлч, 10-р сарын эхээр хөрсийг нэвчтэл норгон услаж өгнө..



Байршил: Ховд аймаг
Мянгад сум,
Технолоийн хамрах хүрээ:
100 га талбай
Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Ургамлын
Уур амьсгал: Хуурай сэрүүн
MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: MNG55
Холбогдох арга барил:
Бүртгэгдээгүй
Технологийг нэвтрүүлсэн:
“Бэлчээрийн Өгөөж” ТББ
Технологийг бүртгэсэн:
Д.Даш
Он, сар, өдөр: 2011.09.12
Эмхэтгэгчдийн тайлбар:

Ангилал:


Газар ашиглалтанд тулгарч буй асуудал: Элсний нүүлт ихсэж элсжиснээс . ургамал нөмрөг сийрэгжиж ургамал нөмрөг доройтож байна.

Газар ашиглалт



Доройтсон бэлчээр бүхий газар байсан бол одоо чацаргана, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын талбай болсон.

Уур амьсгал



Хуурай сэрүүн

Доройтлын хэлбэр




Биологийн доройтол: биомасс буурах



Салхины элэгдэл:

Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл



Ургамлын: Чацаргана, ; ногоо тариа (салхи хаах)

Техник үүрэг /үзүүлэх шууд нөлөө:

- Өнгөн хөрсний бүтцийг сайжруулах
- Ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх
- Хөрсөн дэхь органик нэгдлийн агууламжийг нэмэгдүүлэх
- салхины хүчийг сааруулах
- биомассыг нэмэгдүүлэх


Техник үүрэг /үзүүлэх дам нөлөө:

- Шороон шуурганаас үүдэлтэй тоосонцорын дэгдэлт багасна


Байгаль орчин

Жилийн

дундаж хур тунадас (мм)



Өндөршил (д.т.д м)




Гадаргын хэлбэр



Налуужилт (%)



Хөрсний гүн (см)



Ургамал ургах хугацаа: 120-90 өдөр (5-8-ээр сар)

Хөрсний үржил шим: Дорой

Хөрсний бүтэц: Элсэрхэг

Гадаргын чулуурхаг байдал:

Органик бодисын хэмжээ: Бага (0.6-1%)

Ус нэвтрүүлэх чадвар: Сул

Элэгдэл эвдрэлд өртөх байдал: Хүчтэй

Агаарын жилийн дундаж температур: 3.4 C°.

Хамгийн их/бага температур: +41/-41

Агаарын хамгийн их/бага даралт:


10 сард 873/мб/, 3 сард 827 /мб/

Агаарын жилийн дундаж даралт: 1054. /гПа/мб/

Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа: Жилд 3120 цаг, 5-6 р сар буюу хамгийн ихдээ 315 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 200 цаг байдаг байна.

Нийгэм-эдийн засаг

Нэг өрхөд ногдох ногоон бүсийн талбай (га)



Газар ашиглалтын эрх: Нээлттэй

Газар эзэмшсэн эсэх:

Төрийн/Нийтийн

Зах зээлийн төрөлжилт: Холимог:

/амь зуулга/ арилжаа наймаа

Шаардагдах техник мэдлэгийн түвшин: Бага : Мэргэжилтэн/газар

ашиглагч

ХАА-аас гадна олох орлого, түүний

ач холбогдол: Орлогын 10%-иас илүү

хувийг үйлдвэрлэл, үйлчилгээнээс

олдог.

Суурин/нүүдэлчин: Суурин

Ядуурлын түвшин: Бага

/10%

Ажилгүйдлийн түвшин:

Дунд/30%

Нийгмийн зохион

байгуулалт: Сайн

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Үйл ажиллагааны дараалал	Байгуулахад гарах зардал /1 худаг гаргахад/, 1 \$-ыг 1420 төгрөгөөр бодов.		
	Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Хамгаалалтын чулуун хашаа барих			
- Чулуу бутлах			
- Чулуу зөөх			
- Чулуу өрөх			
2. Талбайг хагалаж бэлтгэх			
3. Худаг гаргах			
4. Услалтын систем тавих			
5. Тариалалт хийх			
6. Ойжуулалт хийх			
	Хамгаалалтын чулуун хашаа байгуулах / 1 га-д 3500м ² , нэгжийн үнэ 100₮	30000000	0%
	Хөрс хагалах /1 га-д /	50	0%
	Худаг гаргах /1ш/	750	0%
	Услалтын систем байгуулах //	750	0%
	Чацарганы суулгац	2250	0%
	Хүнсний ногоо тариалах	100	0%
	Ойжуулалт хийх		
	Нийт	3950	0%

Хүн хүчний өртөг Бусад хөрөнгө оруулалт

	Их		Их
	Дунд		Дунд
	Бага		Бага

Засварлан, сайжруулах үйл ажиллагаа	Урсгал зардал 1жилд /га-аар/		
	Гарах зардал	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1.Тодорхой хугацааны давтамжтай хамгаалалтын хашааг янзалж засах			
	Хашааг засварлах	100	0%
		200	0%
	Нийт	300	0%

Үр ашиг /газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Бага зэрэг эерэг	Эерэг
	Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Бага зэрэг эерэг	Сөрөг

Технологийн нөлөөлөл

Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг

Ургац нэмэгдсэн
Тэжээлийн чанар сайжирсан
Байгалийн гамшигийн эрсдэл буурсан
Усалгааны усны хүртээмж чанар сайжирсан
Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн

+ + +

Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал

байхгүй

Нийгэм соёлын үр ашиг

Хамгаалалт, доройтлын талаарх мэдлэг нэмэгдсэн
Хүнсний аюулгүй байдал сайжирсан
Эрүүл мэндийн байдал сайжирсан

+ + +

Нийгэм соёлын алдагдал

байхгүй

Экологийн үр ашиг

Ургац хураалт сайжирсан
Хөрсний чийг нэмэгдэж, хөрсөн бүрхэвч сайжирсан
Хөрс хагасах байдал буурсан
Ууршилт багассан, биомассын хэмжээ нэмэгдсэн

+ + +

+ + +

+ + +

Экологийн алдагдал

+ Хөрс нимгэрсэн

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруул Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах

Технологи газар ашиглагчийн тариалсан хэмжээнд хүрэх тохиолдолд доройтсон газрыг сэргээн сайжруулах, ард иргэдийн идэвхийг дээшлүүлэх хч холбогдолтой юм → санхүүгийн одоогийн хүндрэлийг туулж чадвал тогтвортой байх нөхцөл бүрдэнэ

Доройтсон газарт чацаргана, хүнсний ногоо ашиг орж болохыг харуулсан → хагалттай зээл тусламж гол нөхцөл болно.

Ард иргэдийн санаачлагаар бий болсон → Олон нийтэд мэдээллийг нээлттэй хүргэж, ач тусыг ухамсарлуулах

Санхүүгийн хүндрэлээс шалтгаалах технологи хэрэгжих ажил удааширч, зогсох нөхцөл байна → газар ашиглагчийн идэвхи санаачлага, нутгийн орны дэмжлэг их хэрэгтэй

Салхины хурд саарсан
Байгалийн гамшигийн эрсдэл буурсан
Амьтны төрөл зүйл нэмэгдсэн
Амьдрах орчин сайжирсан

+ + +

+ + +

Дам үр ашиг

байхгүй

Дам сул тал

байхгүй

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn